

ДОРНОД АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2025 ОНЫ
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025-06-10

Хэрлэн сум

УДИРТГАЛ

Тус төв нь 2025 оны хагас жилд Захиргаа аж ахуй, Цаг уур, орчны технологийн хэлтэс, Мэдээлэл үйлчилгээний хэлтэс гэсэн 2 хэлтэс, 10 нэгжтэйгээр үндсэн 73, гэрээт 2 албан хаагчтайгаар ажилласан. Байгууллагын нийт албан хаагчдын 72.6 хувь нь эмэгтэй, 27.4 хувь нь эрэгтэй албан хаагчтай, албан хаагчдын боловсролын байдлаар нь авч үзвэл: Бүрэн дунд 46.6 хувь, Бакалавр 49.3 хувь, Магистр зэрэгтэй 4.1 хувь, 34.2 хувь нь 40 хүртэлх насны залуу боловсон хүчин ажиллаж байна. Мөн Даргын дэргэдэх зөвлөл, Ёс зүйн хороо, Өмч хамгаалах байнгын ажиллагаатай зөвлөл, Гамшгаас хамгаалах штаб, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн зөвлөл, Залуучуудын зөвлөл, Ахмадын зөвлөл, Сургалт сурталчилгаа хариуцсан ажлын хэсэг, Баримт бичиг нягтлан шалгах комисс ажиллаж байна.

Нийт албан хаагчдын цалин хөлс болон бусад төсөвт 2,357,520.2 мянган төгрөгийн төсөв батлагдсан.

Удирдлагын бодлого, зохион байгуулалт, ил тод байдал:

Тус төвийн Цаг уур, орчны технологийн хэлтэс 59 албан хаагчтайгаар, Мэдээлэл үйлчилгээний хэлтэс 10 хүний бүрэлдэхүүнтэй 2025 оны хагас жилийн төлөвлөгөөт ажлаа гүйцэтгэлээ. Салбаруудын шинжилгээний ажлын хөтөлбөрийн биелэлт, ажиглалтын чанарт хяналт тавьж “Ус цаг орчны хяналт шинжилгээний тухай” хууль, “Технологийн сахилгын дүрэм”-ийг мөрдүүлж, сахилга, хариуцлага, дэг журмыг мөрдүүлж ажиллаж байна.

Үйл ажиллагаандаа “Хөдөлмөрийн тухай” хууль, “Ус цаг уур, хяналт шинжилгээний тухай” хууль, “Хэмжилзүйн тухай”, “Төсвийн тухай” хууль, “Төрийн албаны тухай”, “Агаарын тухай хууль”, “Усны тухай хууль”, “Гамшгаас хамгаалах тухай хууль”, “Авлигын эсрэг хууль”, “Хүн төвт-Хөгжлийн хөтөлбөр”-үүд болон холбогдох хууль, тогтоол, заавар журмыг ажилдаа мөрдлөг болгон, Цаг уур, орчны шинжилгээний газраас батлан гаргасан Ус, цаг уур, байгаль орчны шинжилгээний хөтөлбөрт ажлын тасралтгүй байдал, технологийн мөрдөлтийг хангах, албан хаагчдын мэргэжил, мэдлэг, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, ус, цаг уур, байгаль орчны мэдээ, мэдээллийг хэрэглэгчдэд шуурхай хүргэх, шинжилгээний ажиглалт, судалгааны чанарыг сайжруулахад чиглүүлэн ажиллав.

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:

2025 оны нийт батлагдсан төсөв 2,893,899.7 мянган төгрөгийн төсөв батлагдснаас 2025 оны эхний хагас жилийн байдлаар батлагдсан төсвийн хүрээнд 1,138,261.3 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж байна 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар төсвийн зардалд тусгагдсан байсан үлдэгдэл төсөв болох 19,202.3 мянган төгрөгийг Сангийн яамнаас буцаан татсан төлөвтэй байна. Үндсэн үйл ажиллагааны орлого 1 дүгээр улиралын байдлаар Цаг агаарын тодорхойлолтын төлбөрт үйлчилгээний орлого 828.5 мянган төгрөг, БОЛШ-ийн шинжилгээний төлбөр 1,519.0 мянган төгрөг төвлөрч нийт 2,347.5 мянган төгрөгийг орлого төвлөрүүлсэн. Нэмэлт санхүүжилтийн дансанд

БОГазраас, Цаг агаарт зориудар нөлөөлөх ажлын санхүүжилт 70 хувийн урьдчилгаа болох 12,600.0 мянган төгрөгийн орлого орсноос, тээвэр шатахууны зардалд 1,927.2 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардлаас 1,623.8 мянган төгрөг зарцуулсан ба 9,049.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Албан хэрэг хөтлөлт

Архив, бичиг хэрэг хөтлөлтийн ажилдаа 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор баталсан албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, Монгол бичгийн стандарт MNS 6395: 2022, Монгол улсын засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 246 дугаар тогтоол, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн Журам шинэчлэн батлах тухай 226 дугаар тогтоол, Монгол хэлний тухай хууль, Монгол улсын баримт бичгийн MNS 5140:2021 Стандарт, Монгол хэлний тухай хуулийг тус тус хэрэгжүүлэн ажилладаг.

Тус байгууллагад ирсэн бичиг-125, Үүнээс хариутай 34 бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн. Явсан бичиг: 129 албан бичгийг гарган баталгаажуулсан.

Албан бланкыг архивын газраар хэвлүүлэн, стандартын дагуу индексжүүлэн бүртгэж, цоожтой шургуулгад журмын дагуу хадгалан ашиглаж байна. Мөн Хос бичгээр албан хэрэг хөтөлнө гэсний дагуу албан бланкыг монгол бичгийн загварт стандартын дагуу хийлгэн архивын газраар батлуулж хэвлэлтэд өгсөн.

ЦУОШГ-аас өгсөн чиглэлийн дагуу Дорнод аймгийн Архивын тасагт Албан бланкыг солиулж дахин хэвлүүлэх захиалга хүргүүлсэн.

Байгууллагын даргын түших тэмдэгийг тамга болгох хүсэлтийг ЦУОШГ-т хүргүүлээд байна.

Байгууллагын архив

Аймгийн ЗДТГ-ын хууль эрх зүйн хэлтэст баримт бичгийн эргэлт, цахим болон цаасан суурьтай баримтын эргэлтийн мэдээг 1 удаа, өргөдөл гомдлын мэдээг 2 удаа хүргүүлсэн.

Байгууллагын архивд төвийн даргаар батлуулсан ХХНЖ-ын дагуу байнга хадгалах 5243 хуудас 123 хадгаламжийн нэгж, түр хадгалах 13216 хуудас 490 хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах 2459 хуудас 52 хадгаламжийн нэгж нийт 20918 хуудас 665 боть архивын баримт хадгалагдаж байна.

Байгууллагад 2009-2013 оны материалд 68 ХН цахим тээгч бүхий цахим сан хадгалагдаж байна. Архивын баримт бичгийг эмхэлж цэгцлэн, тоо бүртгэлийг зааврын дагуу хөтлөн, Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг байгууллагын даргаар баталгаажуулан, мөн БНШК-ын шийдвэрээр баталгаажуулж байна. Өрөө тасалгааны чийгшлийн бүртгэлийг өдөр тутамд бүртгэдэг.

2025 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад 49 нэр төрлийн баримтыг архивлахаар батлуулсан байна.

2025 оны хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд:

НЭГ.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт

Дорнод аймгийг 2021-2025 оны хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Дорнод аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд дараах ажлууд тусгагдсан, 3.5.6 дахь заалт Агаар орчны бохирдлыг бууруулахад иргэдийн оролцоог хангах, хандлагыг өөрчлөх

чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулж, хогны менежментийг сайжруулах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн.

ХОЁР. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт

Хоёр. Стратеги төлөвлөгөөний зорилго: Ус, цаг агаар, байгаль орчны төлөв байдалд байнгын хяналт шинжилгээ хийж, бодит болон урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс сэрэмжлүүлэх зорилтын хүрээнд нийт 8 зорилтоор 44 арга хэмжээг тусгаж 94,6 хувьтай дүгнэгдээд байна.

ГУРАВ. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт

Зорилт 3.1: Төвийн салбаруудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагааны менежментийг боловсронгуй болгох, салбарын удирдлагын манлайллыг хангах ажлын хүрээнд 4 зорилтын хүрээнд нийт 19 арга хэмжээг тусгасан бөгөөд хэрэгжилт 97,5 хувьтай байна.

Тус төв нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам, аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн А/447 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаа, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, үнэлж, дүгнэх журам”-ын дагуу тайлагнан 3 бүлэг бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт- шинжилгээ, үнэлгээг хийв.

“Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Төрийн байгууллагад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг байгууллагын хэмжээнд тогтол мэдээлж, хэрэгжилтийг хэлбэрэлтгүй мөрдүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, сургалт нөлөөллийн ажлуудыг хийж байна. Сургалт, сурталчилгаа хариуцсан ажлын хэсэг нь тус төвийн хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх, давтан сургах, мэргэшлийг дээшлүүлэх, сургалт сурталчилгаа хариуцаж ажиллах зорилгоор 5 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Ажлын хэсэг нь 2025 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг жилээр гарган Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн даргаар батлуулан, төлөвлөгөөний дагуу сургалт, семинарт хамрагдах болон зохион байгуулах, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Засгийн газар, дээд байгууллага, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан танхимын сургалт 22, цахим сургалт 15 нийт 49 сургалт, семинарт оролцсон ба үүнээс ажлын байран дахь сургалт 5, мэргэшүүлэх сургалт 5, бусад сургалтын тоо 12 байна.

Нийт давхардсан тоогоор байгууллагын 136 албан хаагч дээрх сургалтад хамрагдсан бөгөөд үүнээс эрэгтэй албан хаагч 29, эмэгтэй 107 албан хаагч байна. Удирдах албан тушаалтан 9 удаа, гүйцэтгэх 127 удаа сургалтад хамрагдсан байна.

2025 оны эхний хагас жилийн байдлаар, албан хаагчдын цалинд ажилласан жилийн нэмэгдэл 69,693.2 мянган төгрөг, мэргэшлийн зэрэг нэмэгдэлд 34,884.8 мянган

төгрөг, ур чадварын нэмэгдлийг 39,879.9 мянган төгрөгийг цалингийн төсвөөс зарцуулаад байна.

Төрийн дээд шагналд 2 ахмад цаг уурч, 5 албан хаагч, Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр 2, Дорнод аймгийн Аймгийн “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр 2, “Жуух бичиг”-ээр 1, нийт 5 албан хаагчийг Үйлдвэрчний эвлэлийн холбоогоор дамжуулан шагналд тодорхойлж, материалыг хүргүүлээд байна.

Төвийн конторын барилга 1974 онд ашиглалтад орж, 51 дэх жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч өнгөрсөн зуны бороонд барилгын дээвэр бүрэн хуурч, урд нүүрийн хана цууралт өгснөөс бүх өрөө нэвчиж, гоожин, ажиллах нөхцөл хүнд байсан тул байгууллагын дээврийн 360 м.кв талбайн засварын ажлыг 05 дугаар сард хийж дуусгасан. Мөн байгууллагын гадаад үзэмжийг сайжруулахад анхаарч, үүдний гадна фасадыг сатникаар өнгөлөн бүрж, байгууллагын гадна хашааг зүүн тал руугаа сунгаж, өнгө будгийг сэргээн засварласан.

Аймаг төр нутгийн захиргааны болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдах ажилтны 2025 оны 14 шуурхай хуралдааны тэмдэглэлээр 29 үүрэг даалгавар өгөгдсөнөөс 100 хувийн хэрэгжилттэй ажиллаж байна.

Аймгийн засаг даргын 2025 оны А/174, А216, А/205, А/88, А/06, А/86 захирамж, Аймгийн засаг даргын 03 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг ханган тайланг мэдээг хугацаанд хүргүүлэн ажиллаж байна.

2025 оны эхний хагас жилийн байдлаар, албан хаагчдын цалинд ажилласан жилийн нэмэгдэл 69,693.2 мянган төгрөг, эрдмийн зэрэг, мэргэшлийн зэрэг дэвийн нэмэгдэлд 34,884.8 мянган төгрөг, ур чадварын нэмэгдлийг 39,879.9 мянган төгрөгийг цалингийн төсвөөс зарцуулаад байна. Шагналд урамшуулалд төсөв зарцуулагдаагүй. 2 албан хаагчид 40 хувь нэмэгдэл цалинг өгч хавсруулан ажиллуулж байна.

БОАЖЯ, ЦУОШГ болон ЗДТГ-аас авч буй албан хаагчдын ажилласан жил, боловсрол, зэрэг, цалин хөлсний судалгааг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

5 өртөө, 20 харуулын ээлжийн амралт, өвчтэй, чөлөөтэй, сургалт, семинарийн үеийн тасралтгүй ажиллагааг төлөвлөн зохион байгуулах зохицуулах, тасралтгүй байдлыг хангах арга хэмжээ авч ажиллаж байна.

Нислэгийн үйлчилгээний техникчийн 1 сул орон тоон дээр нээлттэй ажлын байрны сонгон шалгаруулалт зарласан байна.

Аймаг сумын хөгжлийн бодлого төлөвлөлт, төрийн үйлчилгээний мэргэжлийн байгууллагын ангилалд хамаарагдах болсонтой уялдуулан боловсон хүчний нөөцийг бүрдүүлэхийн тулд ХААИС-ийн Агро-Экологи бизнесийн сургуулийн цаг уурын инженерийн ангид цаг уурын инженерээр 3 албан хаагч суралцаж мөн Монгол улсын их сургуулийн зүүн бүсийн харьяа Дорнод дээд сургуулийн хаврын элсэлтээр цаг уурын бакалаврын ангид 7 албан хаагч суралцахаар бүртгүүлээд байна.

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн дагуу ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, албан хаагчдад байгууллагын facebook хаягаар мод тарих зөвлөмжүүдийг тогтмол өгч ажиллаж байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн бүх нийтээр мод тарих аяны хүрээнд 5 дугаар сарын 11-нд Найрамдал цэцэрлэгт хүрээлэнд болсон нээлтийн үйл ажиллагаанд байгууллагаараа хамрагдсан.

Нисэхийн зам дагуу хувиарлагдсан газарт нийт 69 ширхэг суулгац суулгаснаас 54 модны ургалтын байдал хэвийн, Үүнээс 15 ширхэг суулгац нь хатсан тул нөхөж 15 ширхэг улиасны суулгац шинээр суулгаж, хаврын усалгаа хийсэн.

5 дугаар сарын 14-нд Хэрлэн сумын 11 дүгээр багийн ажлын албатай гэрээ байгуулж, 10 ширхэг Нарс мод хүлээн авч байгууллагын хашаанд суулгаж, усалгаа хийж, гаднах моднуудыг тайрч, хэлбэржүүлж засаж, усалгаа хийсэн.

“Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагын албан хаагчид болон Байгууллагын фейсбүүк хуудсанд 2 удаа мэдээлэл байрлуулан 36 албан хаагч мэдээлэлтэй танилцсан байна.

Ёс зүйн дэд хороо нь “Нэгдье” аяны хүрээнд төвийн нийт албан хаагчдад нөлөөллийн ажлыг цахимаар хийсэн. Ёс зүй, авлигын сургалт нөлөөллийн ажлыг цахимаар 2, танхим 1 удаа хийж, нийт 34 албан хаагч хамрагдсан.

“Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг төвийн байранд байршуулан мэдээллийг шинэчлэн ажиллаж байна.

Гэрээт шинжилгээний ажлыг хамтран хийж гүйцэтгэдэг аж ахуй нэгжээс үйлчилгээний талаарх саналыг журмын дагуу авч үйл ажиллагаагаа сайжруулан итгэмжлэгдсэн лабораторийн үр дүнг цахим хаягаар зураг хэлбэрээр хүргүүлэх, цаг агаарын тодорхойлолтыг цахимаар хүсэлт авч хариуг хүргүүлэн ажилласан.

Аймгийн засаг даргын “Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний тухай” А/86 дугаар захирамжийн хүрээнд, 2025 оны 03 дугаар сарын 17-ноос 06 дугаар сарын 07 -ныг хүртэл хуурайшилтын зэрэглэлийг бодож, хүснэгт болон текст хэлбэрээр 83 удаа боловсруулж, Дорнод аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн пэйж хуудсанд 83 удаа байршуулж, 30710 иргэдийн хандалттай байна.

Гурав. Цаг уур, орчны шинжилгээний газраас батлагдсан хөтөлбөрийн хүрээнд:

1. ЦАГ УУР, ОРЧНЫ ТЕХНОЛОГИЙН ХЭЛТЭС

1.1 Удирдлагын бодлого, зохион байгуулалт, ил тод байдал:

Тус хэлтэс нь 59 албан хаагчтайгаар 2024 онд төлөвлөсөн ажлаа бүрэн ханган ажиллалаа. Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай”, “Төрийн албан хаагчийн тухай”, “Хэмжлийн нэгдмэл байдлын тухай” хууль бусад эрх зүйн хүрээнд хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явууллаа.

Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын ажлын чиглэлээр тайлан мэдээ хүлээн авах хуваарийг оны эхэнд гаргаж, Засаг даргын 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр,

аймгийн эдийн засаг, нийгмийг 2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан ажлууд, үндэсний хөтөлбөр, төсөл дэд хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, өргөдөл гомдлын тайлан мэдээнүүдийг цаг хугацаанд нь аймгийн засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Төрийн захиргаа удирдлагын хэлтэс, Хууль эрх зүйн хэлтэс, Хяналт шалгалт дотоод аудитын хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтсүүдэд хүргүүлж ажилласан.

Салбаруудын шинжилгээний ажлын хөтөлбөрийн биелэлт, ажиглалтын чанарт хяналт тавьж “УЦУОХШинжилгээний тухай” хууль, “Технологийн сахилгын дүрэм” болон сахилга, хариуцлага, дэг журмыг мөрдүүлж, ЦУОШГ-ын мэргэжилтнүүдийн зааварчилгааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хэлтсийн үйл ажиллагаатай гомдол, санал ирээгүй.

Ажиглалтын журам, заавар зөрчсөн Улз-Дашбалбар харуулын техникч О.Мэргэнбүүвэй сахилгын 2 сар 20 хувь шийтгэл оногдуулж, алдаа дутагдлыг давтан гаргахгүй байх үүрэг чиглэлийг өгч залруулж ажиллаж байна.

Байгаль орчны шинжилгээний лабораторийн технологич инженер ар гэрийн гачигдал гарсан тул өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт гаргасны дагуу чөлөөлж, декритний амралттай байсан албан хаагч ажилдаа орж, салбар дотор томилгоо хийсэн.

Халхгол станцад 2020 онд суурилуулсан хятад MD-801 автомат станцыг сольж, Финляндын AWS-310 автомат суурьлуулж, ажиллагаанд оруулсан. Ажиллагаа хэвийн.

Халхгол станцын Хятад MD-801 автоматыг Эрээнцав харуулд шилжүүлэн суурилуулах бөгөөд харуулын газрыг нүүлгэн шилжүүлэх ажил шийдэгдсэний дараа автоматыг суурилуулах ажил хийгдэхээр төлөвлөн ажиллаж байна.

Хятадын Хөрсний гүний термометрийг 06 дугаар сарын 04-нд Чойбалсан өртөөнд шинээр суурилуулсан. Нарны дэлгэц, батареийг шинэчилж, ажиглалтыг 6 сардаа багтаан эхлүүлэхээр бэлтгэж байна.

Цаг уурын Матад өртөөний ажиглалтын хашааг 16*16 томруулах, Хөлөнбуйр харуулын ажиглалтын хашааг нүүлгэн 12*12 хэмжээтэй болгож томруулах санхүүг дотоодын нөөц боломжоор шийдвэрлэн, албан хаагчид өөрсдийн хүчээр хийж байна.

1.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар

Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаанд чиглэлээр албан хаагчдын хөдөлмөр хамгаалалд 7584000 төгрөгийн бараа материалын хангалт хийсэн. Үүнд: өвлийн хувцас 25 ширхэг –5 өртөө, цаг уурын харуул 10, ус судлалын 10 харуулд, усны гутал –15 ширхэг, гар чийдэн – 15 ширхэг, усны конбинзон –13 ширхэг.

2. УС, ЦАГ УУР ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ УЛСЫН СҮЛЖЭЭНИЙ ТОГТВОРТОЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ

ЦУОШГазрын даргын 2016 оны 02 тоот тушаалаар батлагдсан ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний ажиглалтын хөтөлбөрийн биелэлтийг хангаж ажилласан.

2.1 Цаг уурын салбар:

Шинжилгээний хөтөлбөрт ажил хэвийн, тасралтгүй хийгдсэн.

Салбаруудын шинжилгээний ажлыг "Ажил дүгнэх журам"-ын дагуу сар бүр дүгнэж, хариу зааварчилга өгч, цаасан болон цахимаар хүргүүлж, утсаар тогтмол харьцаж ажилласнаар цаг уурын өртөө, харуулуудын ажиглалтын чанарыг ахиулан ажилласан.

Хөтөлбөрт ажил

- Цаг уурын 5 станц, 10 харуулын шинжилгээний ажлын 2024 оны 12 дугаар сараас 2025 оны 5 дугаар сарын ISX-180 ширхэг, TAB-180 ширхэг, шалган техник болон орон зайн онолын шүүмж шалгалтыг хийж, УЦУОСМХ-ийн УАӨНСС-т сар бүрийн 15- 20-нд хугацаа хоцролгүй 100% явуулсан.
- CAMS-620 нарны автомат станцын мэдээллийг 6 удаа шалгаж шүүмж шалгалт хийсэн.
- Станц харуулуудаас 10 хоногийн агро дундаж мэдээг 15 удаа авч шалгаж УЦУОСМХ-ийн ХААЦУ-ын секторт сар бүрийн 1,11, 21-нд 100% дамжуулсан.
- Сар бүрийн уур амьсгалын тоймыг сайтад 6 удаа бичиж байрлуулсан.
- MONMETEO программыг шүүмж шалгалт хийхэд ашиглаж сарын элементийн түүвэр эмхэтгэл гаргах, тархалтын зураглал, элемент хоорондын график, элементүүдийн экстермаль утгуудыг хянахад ашиглаж байна.
- Сар бүр шинжилгээний ажлын тайлан шалгаад хариу зааварчилгаа бичиж гаргасан үл тохирлыг засах талаар салбар бүрд хүргүүлэн ажилласан.

Мэдээллийн нэгдсэн санд нөхөн бүрдүүлэлт хийх

- Халхгол, Матад, Дашбалбар, Онон өртөөний 2023 цаасан суурьтай шинжилгээний баримт ЦД-1, ЦД-7, Дашбалбар өртөө термограф-365 ширхэг, гигрограф 365 ширхэг, барограф-52, Матад өртөө термограф-365 ширхэг, гигрограф 365 ширхэг, барограф-52, Халхгол өртөө термограф-365 ширхэг, гигрограф 365 ширхэг, барограф-52 ширхэг өөрөө бичигчийн лентүүд, ХАА-н таримал ургамлын ХД-2, ХД-5, ХД-7б, ХД-7а дэвтэр, Баяндун, Баянтүмэн, Булган, Гурванзагал, Сэргэлэн, Цагаан-Овоо, Халхгол, Хөлөнбуйр, Хэрлэн, Эрээнцав харуулуудын ХАА-н цаг уурын ХД-1а, ХД-7б, ХД-7а дэвтрүүдийг дугаарлан үдэж, цаасан материалыг хавтаслаж хүлээлгэн зааврын дагуу цэгцлэн үдэж, ЦУОШ Газрын даргын 2016 оны 4 дүгээр сарын 11-ний А/34 тушаалаар батлагдсан "Баримт хүлээн авах акт"-аар АМДСанд хүлээлгэн өгсөн.
- Халхгол, Матад, Дашбалбар, Онон, Халхгол, Матад өртөө, Баяндун, Баянтүмэн, Булган, Гурванзагал, Сэргэлэн, Цагаан-Овоо, Халхгол, Хөлөнбуйр, Хэрлэн, Эрээнцав харуулуудын агаарын температурын үзүүлэлтүүд, хур тунадасны үзүүлэлтүүд, хөрсний температурын үзүүлэлтүүд, бороо, аадар бороо, цастай өдрийн тоо бороо, аадар бороо цасны үргэлжлэх хугацааны түүвэр хийсэн.

Шинэлэг санаа, хэрэгжүүлсэн арга хэмжээ

Онон өртөө: Баян-Уул сумын түүхт 100 жилийн ойн ажлын хүрээнд сумаас өгсөн банз модыг ашиглан модон жорлон, гаднах сүүдрэвч шинээр хийсэн. Үүнд дагалдах материал болох будаг, дээврийн төмөр, хадаас, шрүпп, ширээ сандал

хийлгэсэн ажлын хөлс зэрэгт нийт 540000 төгрөг. Хашаалсан талбайн шон, өргөстэй торыг солихоор авсан материал, тээврийн зардалтайгаа 750000 төгрөг гээд хагас жилд хийсэн ажилд нийт 1300000 төгрөг зарцуулсан.

Дашбалбар өртөө:

- Өртөөндөө ажлын багаж хүрз, тармуур авсан
- Монгол улсын зураг шигтгээтэй наамал 30,000 төгрөг
- Ажилчдадаа өрөөндөө ая тухтай байхад зориулж ДДШ-ТВ сунгалт 6 сар $6 \times 15,000 = 90,000$ төгрөгөөр сунгасан.
- Ажиглалтын хашааны хаяг 65,000 төгрөгөөр хийлгэсэн.
- Өртөөний байшингийн дээвэр будахад 10л 80,000 төгрөгийн будаг. Төвөөс 28л будаг 1ш будаг шингэлэгч 1багц өгсөн, Ажиглалтын хашааны тор 2 агаарын өөрөө бичигчийн бүхээг, тунадас хэмжигч 200,000 төгрөгийн будаг, багц, өнхрүүш, будаг шингэлэгч нэмж авч байгууллагын өнгө үзэмжээ сайжруулав.
- Монгол улсын далбаа 45.000 төгрөгөөр авсан.
- Цаг уурын өртөөний туг 125,000 төгрөгөөр хийлгэсэн.
- Туганы иш $2 \times 42,500 = 85.000$ төгрөгөөр авсан.
- Ажиглалтын талбайн замын хашлага тоосгоор хийсэн .50,000 төгрөгөөр хайрга татаж замаа янзалсан.

Булган харуул

- Цаг уурын ажиглалтын талбайг 12*12 болгох кадастрын зураглал хийлгэсэн.

2.2 Хөдөө аж ахуйн салбар:

Дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт

- Хөдөө аж ахуйн цаг уурын ажиглалтын Зудын эрсдэлийн үнэлгээ, өвөлжилтийн тойм, ургамалжилтын мэдээг “Дорнод аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв” фэйсбүүк хуудсанд байршуулсан ба нийт хандалтын тоо нь 8982 хэрэглэгчид хүрсэн байна.
- Бэлчээрийн төлөв байдлын ажиглалтын ХД-8-ын ажиглалтын чанар 99.9%, шүүмж шалгалт 100% буюу нийт 1.6 хувиар ахисан үзүүлэлттэй байна.
- Агро дундаж мэдээг 10 хоног бүр ахлах техникчид болон ерөнхий технологич үе шаттайгаар шалгаж, бэлчээрийн ургамлын үе шатны хүснэгтийг өртөө харуул бүрээр гаргаж, алдаа дутагдлыг дор бүр нь засаж залруулсан үр дүнд хагас жилийн дүнгээр 100% буюу өмнөх оноос 0.55 хувиар ахисан үзүүлэлттэй байна.

Боловсон хүчнийг хөгжүүлэх талаар

- Хөдөө аж ахуйн цаг уурын ажиглалтын талаарх зөвлөмжийг ХААЦУ-ын ерөнхий технологич болон салбар хариуцсан ахлах техникч нар нийт 5 удаа цахимаар танилцуулсан байна.
- Хөдөө аж ахуйн цаг уурын өртөө, харуулуудад бэлчээрийн ургамлын цухуйлтаас эхлэн агро дундаж мэдээн дээр гарч буй үл тохирлыг засах талаарх заавар зөвлөмжийг инженер болон ахлах техникч нар утсаар болон цахимаар өгч ажиллаж байна.

- 2025 оны 03 дугаар сарын 13-нд ХААЦУ-ын ерөнхий технологич Б.Уранцэцэг Агродундаж мэдээний 800 дугаар бүлгийн бүрхэг өдрийг мэдээнд өгөх талаарх зөвлөмж, хичээлийг цахим хэлбэрээр өртөө харуулын албан хаагчдад хүргэв.
- Хөдөө аж ахуйн цаг уурын Хэрлэн харуулын техникч Г.Уянгад Бэлчээрийн ургамлын үзэгдэл зүйн ажиглалт, хортон мэрэгчдийн ажиглалт, АК-02 кодыг 3 дугаар сарын 24-27ны өдрүүдэд зааж сургасан.
- 2025 оны 04 дүгээр сарын 09-нд ХААЦУ-ын ерөнхий технологич Б.Уранцэцэг бэлчээрийн ургамлын цухуйлт болон ургамлын ургалтын байдлыг үнэлэх сэдвээр өртөө харуулын техникчдэд цахимаар зөвлөмж, хичээл орсон.
- 2025 оны 04 дүгээр сарын 18-нд ахлах техникч Ж.Бумдарь Мэрэгчдийн нягтшиллын ажиглалт сэдвээр өртөө харуулын техникчдэд цахимаар зөвлөмж, хичээл орсон.
- 3.7 2024 оны 6 дугаар сарын 04-нд бэлчээрийн ургамлын ургац болон бүрхцийг үнэлэх талаарх зөвлөмж, хичээлийг цахимаар ахлах техникч Б.Балжид орсон.

Хөдөө аж ахуйн цаг уурын урьдчилсан мэдээ, тойм, зөвлөмжөөр үйлчлэх мэдээллийг төв орон нутгийн хэмжээнд гаргаж ард иргэд, аж ахуйн нэгж, орон нутгийн удирдлагыг мэдээллээр хангах стратегийн зорилтын хүрээнд:

- 2024 оны хөрс гэсэх хугацааны урьдчилсан мэдээ, Хаврын угтвар чийгийн урьдчилсан мэдээг тус бүр <http://dornod.tsag-agaar.gov.mn/> сайтад болон “Дорнод аймгийн Ус, цаг уур , орчны шинжилгээний төв” фэйсбүүк хуудсан байршуулдаг ба нийт хандалтын тоо нь 2647 байна. Мөн төр, захиргааны байгууллага болон аж ахуйн нэгжид шуурхай мэдээлж ажилласан.
- Дорнод аймгийн хэмжээнд зудын үнэлгээг 2024 оны 12 дугаар сараас 2024 оны 03 дугаар сарын 20-ныг хүртэлх хугацаанд нийт 5 удаа гаргаж ажилласан ба “Дорнод аймгийн Ус, цаг уур , орчны шинжилгээний төв” фэйсбүүк хуудсанд 9 удаа байршуулж нийт 8947 хэрэглэгчдэд хүрсэн байна
- Хэрэглэгчдийг мэдээллээр хангах ажлын хүрээнд хөдөө аж ахуй цаг уурын 10 хоногийн тойм мэдээг аж ахуй нэгж, албан байгууллагууд болон <http://dornod.tsag-agaar.gov.mn/> веб сайтад 15 удаа, “Дорнод аймгийн Ус, цаг уур , орчны шинжилгээний төв” фэйсбүүк хуудсанд өвөлжилтийн тойм болон цасан бүрхүүл, зудын эрсдэл, ургамалжилтын зураглалыг 12 удаа байршуулж, нийт 37 удаагийн мэдээллээр тус бүр хэрэглэгчдэд үйлчилж, хандалтын тоо 9511 хүнд хүргэсэн байна.

Ус цаг уур, орчны шинжилгээний улсын сүлжээний нэгжүүдийг арга зүй, технологийн удирдлагаар хангаж, тэдний тасралтгүй хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх. Хяналт шинжилгээнд ашиглаж буй хэмжих хэрэгсэл, багаж төхөөрөмжийн үзлэг үйлчилгээ, шалгалт тохируулгыг тогтмол хийж хэмжлийн нэгдмэл байдлыг хангах стратегийн зорилтын хүрээнд:

Шинжилгээ судалгааны хөтөлбөрт ажил

- Хөдөө аж ахуйн цаг уурын өвлийн явуул судалгааны ажиглалтыг энэ онд 2 өртөө, 4 харуулд хийсэн байна. ХХ-26 хүснэгтэн шүүмж шалгалт хийж, ХААЦУ-ын хэлтэст хүргүүлэв.
- Дорнод аймгийн цасан бүрхүүл, мал өвөлжилт зудын байдалд хийсэн явуул судалгааны тайлан, зураглал, тайлбарыг 2025 оны 01 дүгээр сарын 25-наас 2

- дугаар сарын 10-ны хооронд өртөө, харуулуудаас хүлээн авч, зураглал ирүүлсэн байдал, мэдээллийг шалган, шүүмж хийж, тайланг хугацаанд нь хүргүүлсэн.
- Бэлчээрийн хортон мэрэгчдийн голомт нутгийн тархалтын хүрээг тодорхойлох ажлыг 2025 оны 2-3 дугаар сард хийсэн ба Бэлчээрийн хөнөөлт мэрэгчдийн голомт нутгийн байрлал, тархалтын хүрээг тодорхойлсон зураглал, тайлбарыг өртөө, харуулуудаас хүлээн авч, зураглал ирүүлсэн байдал, мэдээллийг шалган, шүүмж хийж, ХААЦУ-ын хэлтэст тайланг хүргүүлж ажилласан.
 - 2025 оны 04 дүгээр сарын 2 дугаар 10 хоногт Чойбалсан, Халхгол, Онон өртөөний хөрсний чийгийн явуул судалгааны ажиглалтыг хийж, ХД-5 дэвтэрт шүүмж шалгалт хийж, ХААЦУ-ын хэлтэст хүргүүлсэн.
 - Бэлчээрийн ургамлын үзэгдэл зүйн ажиглалтыг технологийн дагуу хийлгэж, тайланг хугацаандаа ирүүлэхэд хяналт тавьж, хүлээн авч ажилласан. Нийт 30 ш ХД-1, ХД-1а дэвтэрт техник болон шүүмж шалгалт хийв.
 - Бэлчээрийн ургамлын хортон, мэрэгчдийн ажиглалтыг технологийн дагуу хийлгэж, тайланг хугацаандаа ирүүлэхэд хяналт тавьж, хүлээн авч ажилласан. Нийт 30 ш ХД-7б дэвтэрт техник болон шүүмж шалгалт хийв.
 - Хөрсний чийгшлийн ажиглалтыг технологийн дагуу хийлгэж, тайланг хугацаандаа ирүүлэхэд хяналт тавьж, хүлээн авч ажилласан. Нийт 8 ш ХД-5 дэвтэрт техник болон шүүмж шалгалт хийв.
 - Бэлчээрийн төлөв байдлын ажиглалтыг 2024 оны 8 дугаар сарын 8-18-ны хооронд 14 сумын 54 цэгт хийж, тайланг хугацаандаа ирүүлэхэд хяналт тавьж, хүлээн авч ажилласан. Нийт 54 ш ХД-8 дэвтэрт техник болон шүүмж шалгалт хийсэн байна.
 - Тухай бүрт нь өртөө харуулуудад хариу зааварчилгаа бичиж хүргүүлэн, утсаар болон шалган туслах ажлаар очиж ажлын алдаа дутагдлын талаар хэлж, хяналт тавин ажилласан.

Хяналт шинжилгээний улсын сүлжээний найдвартай ажиллагааг хангах, сүлжээг өргөтгөх, улсын сүлжээнд мөрдөх хөтөлбөр, технологи, стандарт, арга зүйг улам боловсронгуй болгох, сайжруулах

- ХААЦУ-ын Чойбалсан өртөөний хөрсний чийг температурын ZL-6, Халхгол өртөөний хөрсний чийг температурын EM-50 автомат багажийн мэдээллийг сард 18 удаа мэдээллийг тогтмол авч, боловсруулан нийт 18 удаа ХААЦУ-ын хэлтэст хүргүүлсэн байна.
- ХААЦУ-ын 4 өртөө, 2 харуулд төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус шалган туслах хийсэн. Үүнд: Халхгол, Чойбалсан, Дашбалбар өртөөд, Халхгол харуул “Хангалттай сайн” Матад өртөө, Хэрлэн харуул “Хэвийн дунд” дүгнэгдсэн.

Шинэлэг санаа, хэрэгжүүлсэн арга хэмжээ

- Хөдөө аж ахуйн цаг уурын Дашбалбар өртөө, Халхгол, Гурванзагал, Булган, Эрэнцав, Баяндун харуулууд нь хөдөө аж ахуйн цаг уурын хашаалаагүй талбайн тэмдэг тэмдэглэгээг сэргээн засварласан.
- Хөдөө аж ахуйн цаг уурын Онон өртөө нь хөдөө аж ахуйн цаг уурын хашаалсан талбайн хашааны торыг шинэчлэн татсан.

ХААЦУ-ын мэдээ, мэдээлэл сурталчилгаа

- АЗДТГазарт өвөлжилтийн тойм мэдээг 1-4 сар хүртэл нийт 6 удаа бэлтгэж өгсөн.
- Аймгийн удирдлагуудын нэгдсэн шуурхай хурал дээр “Өвөлжилтийн цаг үеийн нөхцөл” сэдвээр 1 дүгээр сарын 13-нд мэдээлэл хүргэсэн.
- ОБЕГазарт дээр зудын эрсдэлийг үнэлэх хэлэлцүүлэгт оролцож, Дорнод аймгийн нийт нутгаар нь зудыг үнэлж 10 дугаар сарын 29-нд ОБЕГазарт хүргүүлсэн.
- Аймгийн ХХААГазараас зохион байгуулсан бэлчээр ашиглах, хамгаалах журмын талаарх хэлэлцүүлэгт 01 дүгээр сарын 15-нд оролцсон.
- ЦУОШГазраас зохион байгуулсан тайлант хэлэлцүүлэгт 01 дүгээр сарын 29-30 ны хооронд оролцсон.
- Адапт төслөөс зохион байгуулсан “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй
- БОУАӨЯамнаас зохион байгуулсан “Уур амьсгалын өөрчлөлт жендерийн асуудал” сэдэвт сургалтад танхимаар 04 дүгээр сарын 14-нд оролцов.

2.3 Байгаль орчны шинжилгээний лаборатори:

ХӨТӨЛБӨРТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ

- **Агаарын чанар:** Агаарын чанарын хяналт шинжилгээг суурин харуулаар хүхэрлэг хий, азотын давхар исэл, PM2.5 тоос гэсэн 3 үзүүлэлтээр ажлын өдрүүдэд 08, 14, 20 цагуудад хэмжилт хийж ажиллаа. Үүнд хүхэрлэг хий, азотын давхар ислийн 732 сорьц, тоосны 180 мэдээг тус тус авсан ба нийт 1464 сорьцод шинжилгээг бүрэн хийж гүйцэтгэж, үр дүнг боловсруулж ажилласан.

Агаарын чанарын нэмэлт явуул судалгааг өвлийн улирал буюу 1-3 дугаар саруудад Хэрлэн сумын 1, 2, 3, 4, 8, 10, 11 дүгээр багуудын нутаг дэвсгэрээс нийт 36 сорьц авч шинжилгээ хийсэн.

7058300Callpro: Агаарын чанарын 10 хоногийн мэдээг 18 удаа байршуулсан

УЦУОШТөвийн фейсбүүк хуудсанд: Агаарын чанарын мэдээ мэдээлэл 18 удаа байршуулсан /хандалт 15.050/

www.dornodtsag-agaar.gov.mn вэб хуудсанд Агаарын чанарын 10 хоног, сарын тойм мэдээг нийт 18 удаа тус тус байршуулан олон нийтийг мэдээ мэдээллээр ханган ажилласан.

- Гадаргын ус болон хаягдал усны чанар

Гадаргын усны чанарын хяналт шинжилгээг ус судлалын харуулын Халх гол- Сүмбэр дээд, доод цэг, Халхгол- Баянхошуу, Халх гол- Буйр нуур, Буйр нуур- Загасны үйлдвэр, Онон- Улз гол, Эрээнцав- Улз гол хяналт шинжилгээний цэгээс 54 усны сорьц хүлээж авч бүртгэл хийн, химийн найрлагын шинжилгээг бүрэн гүйцэт хугацаанд нь хийсэн.

Төв цэвэрлэх байгууламжийн орох, гарах хэсгээс 12 сорьц авч, химийн найрлагын шинжилгээг хийсэн.

УЦУОШТөвийн фейсбүүк хуудсанд: Усны чанарын тойм мэдээг 6 удаа байршуулсан.

www.dornod.weather.gov.mn вэб хуудсанд: Гадаргын усны чанарын төлөв байдлын мэдээг 12 удаа байршуулсан.

- Цацраг

Цацрагийн түвшний 1376 удаагийн ажиглалтыг Чойбалсан, Халхгол өртөөнүүд тасралтгүй хийж гүйцэтгэсэн.

Уналын сорьцын нийлбэр бета идэвхийн сорьцыг сар бүрийн 2, 12, 22-нд авч нийт 18 сорьцод анхан шатны боловсруулалт хийн тайланг хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Цацрагийн шинжилгээг хийх усны дээжийг Хэрлэн голын 3 чиглэлээс авч анхан шатны боловсруулалт хийн 5 дугаар сарын эхний 7 хоногт Байгаль орчин хэмжилзүйн лабораторийн цацрагийн хэсгийн ахлах инженерт хүргүүлэн ажилласан.

- Хөрсний чанар

Хөрсний чанарын хяналт шинжилгээний хөтөлбөрт 19 цэгээс агрохими, хүнд элемент сорьцыг тус бүр авч анхан шатны боловсруулалт хийн агрохимийн шинжилгээг хийж гүйцэтгэсэн.

Хөтөлбөрт хяналт шинжилгээгээр агаарын чанарын хяналт шинжилгээний 912 сорьц, гадаргын усны чанарын хяналт шинжилгээний 13 цэгийн 54 сорьц, хөрсний чанарын хяналт шинжилгээний 19 сорьц, Цацрагийн түвшний 1376 хэмжилтийг тус тус хөтөлбөрийн дагуу тасралтгүй бүрэн хийж гүйцэтгэсэн.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Дотоод хяналтын ажил

Дотоод хяналтыг 6 удаа агаар, ус, цацрагийн шинжилгээний үр дүнд Агаарын чанарын тайланг I/2, II/3, III/6, IV/1, V/1, VI/2-нд, Усны чанарын тайланг I/27, II/27, III/26, , V/1, VI/2-нд тус 6 удаа, Цацрагийн түвшний тайланг I/2, II/3, III/6, IV/1, V/1, VI/2-нд тус тус хянасан.

Агаарын жиших муруйг 1,2 улиралд NO_2 , SO_2 хоёрын үзүүлэлтээр тогтоон нийт 2 удаа хийж тайланг БОХЗТЛ-т хугацаанд нь хүргүүлсэн.

Усны чанарын хяналт шинжилгээг 1, 2 улиралд 17 үзүүлэлтээр нийт 2 удаа шинжилгээг Эрхлэгч Б.Гүнчинсүрэн, технологич инженер О.Оюунбилэг, инженер Ж.Гэрэлтуяа, Г.Ганцэцэг нар АЕ-S60-4V спектрофотометр ашиглан жиших муруйг тодорхойлон тайланг БОХЗТЛ-ийн усны инженерт хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Гадаад хяналтын ажил

БОХЗТЛлабораторитой харьцуулах шинжилгээг Хэрлэн голын 3 дугаар чиглэлээс 2 сорьц авч 5 дугаар сард хийсэн.

Хэнтий аймгийн УЦУОШТөвийн БОШ Лабораторид Хэрлэн голын дээд чиглэлээс 3 дугаар сард дээж лаборатори хоорондын харьцуулалтын шинжилгээг хийсэн.

Усны чанарын хяналтын сорьцод 5 дугаар сарын 16-нд PO_4 , NO_2 , NH_4 , NO_3 , SO_4 гэсэн 5 үзүүлэлтээр шинжилгээг хийж үр дүнг БОХЗТЛлабораторид цахимаар хүргүүлсэн.

Агаарын чанарын хяналтын сорьцод 4 дүгээр сарын 10,11-ний өдрүүдэд хүхэрлэг хий, азотын давхар исэл гэсэн 2 үзүүлэлтээр шинжилгээг хийн үр дүнг БОХЗТЛлабораторид цахимаар хүргүүлсэн.

Хөрсний чанарын хяналтын сорьцод 5 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд NH_4 , SO_4 рНметр гэсэн 3 үзүүлэлтээр шинжилгээг хийн үр дүнг БОХЗТЛлабораторид цахимаар хүргүүлсэн.

ТЕХНИК ШАЛГАЛТ

Ус: Гадаргын усны шинжилгээний ажлын дэвтэр, хүснэгт болох УБХ-2, 4, 5, 6, 7, 9, 8,10 –г шалгаж УБХ-1 тайланд 6 удаа, Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал усны тайланд 12 удаа тус тус техник шалгалт хийсэн. Мөн мэдээллийн сангийн үр дүнгийн шивэлтэд хяналт шалгалтыг 6 удаа хийсэн.

Агаар: Агаарын чанарын шинжилгээний тайлан АЧХ-1, 2, 3 хүснэгт, АЧД-1 дэвтэрт тус бүр 12 удаа техник шалгалт хийж, мэдээллийн сангийн 912 үр дүнгийн шивэлтэд ажлын өдөр бүр хяналт тавьж гарсан алдааг тухай бүрд нь залруулан ажилласан.

Цацраг: Цацрагийн түвшний ажиглалтын Чойбалсан, Халхгол өртөөний хэмжилтийн үр дүнг eic.mn мэдээллийн санд шивсэн 1376 мэдээг ажлын өдрүүдэд тогтмол хянаж, мөн ЦТХ-1 тайланд 6 удаагийн техник шалгалт хийсэн.

БАГАЖ, ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙН ШАЛГАЛТ ТОХИРУУЛГА, ҮЗЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

24 багаж, тоног төхөөрөмжийн паспорт болон цаг ашиглалтыг ЖР-6.4-МГ-1-25-н маягтын дагуу тухай бүрд хөтөлж ажилласан. Суурин рНметр, кондуктометрийг 6 удаа буфер уусмалаар завсар дундын тохируулга хийсэн. Цөмийн энергийн төв лабораторид 2025 оны 4 дүгээр сарын 6-14-ний хооронд Чойбалсан, Халхгол өртөөний цацрагийн RDS-110, АТ61-30 багажуудад шалгалт тохируулга хийлгэсэн.

Стандарт хэмжил зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Батзориг нь 6 дугаар сарын 5-нд аналитик жин, техник жинг тус тус шалгалт тохируулга хийлгэсэн.

ГЭРЭЭТ БАЙГУУЛЛАГЫН ЗАХИАЛГАТ АЖИЛ

Аж ахуй нэгж, иргэний хамтран ажиллах хүсэлтийг 15 удаа хүлээн авч гэрээ хийн 5 дугаар сард агаарын 50, усны 30, хөрсний 23 дээж авч шинжилгээг хийн ажиллаж байна.

МЭДЭЭЛЛИЙН САН ҮҮСГЭЛТ

Гадаргын усны шинжилгээний 54 сорьцын 18-20 үзүүлэлтийн үр дүнг мэдээллийн сангийн "Цаг уур орчны шинжилгээний газрын мэдээллийн сан" программд 6 удаагийн шивэлт хийн байршуулсан.

Төв цэвэрлэх байгууламжийн орох гарах хэсгийн 12 сорьцын үр дүнг 6 удаа мэдээллийн санд шивсэн.

Агаарын чанарын шинжилгээний 3 элементийн үр дүнг, цаг агаарын 6 элементийг мэдээллийн сангийн "Цаг уур орчны шинжилгээний газрын мэдээллийн сан" программд шивэлт хийж байршуулсан.

EIC.mn сайтад Чойбалсан, Халхгол өртөөний цацрагийн түвшний ажиглалтын 1376 үр дүнг мэдээллийн санд оруулсан байдалд хяналт хийн шалгасан.

"Орчны бохирдлыг эх үүсвэр"-ийн мэдээллийн санд оруулсан. 2024-2025 оны Агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогыг аймгийн хэмжээнд зохион байгуулан тайланг нэгтгэж 2 дугаар сарын 17-нд ЗДТГазар, ЦУОШГазар тус тус хүргүүлсэн. Тооллогын үр дүнгээр Ердийн галлагаатай 3-15 квт хүртэл хүчин чадалтай 7936 зуухны нь 60.855 тн нүүрс, 10950 м³ мод, 2862 тн бусад түлш хэрэглэсэн байна. 15-100квт хүртэл хүчин чадалтай 86 зуух нь 14.524тн нүүрс хэрэглэсэн. Усан халаалтын 100-4200 кВт хүчин чадалтай 21 зуух нь 15.520тн нүүрс хэрэглэсэн. 4200квт хүчин чадалтай 7 зуухны нь 623451.3тн нүүрсийг тус тус хэрэглэсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Дорнод аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/445/А568 тоот хамтарсан тушаал, захирамжаар Чойбалсан хотын агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөгдөх журмын батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Шинэлэг санаа, хэрэгжүүлсэн арга хэмжээ

Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 1, 5, 12 дугаар ангийн сурагчдад ус, агаарын чанарын үр дүн болон лабораторийн үйл ажиллагааг танилцуулав.

Багаж тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг ханган цацрагийн RDS-110, AT61-30 багаж, аналитик жин, техник жинг тус тус шалгалт тохируулга хийлгэсэн.

ИТГЭМЖЛЭЛ

MNS ISO/IEC17025:2018 стандартын шалгуур үзүүлэлт “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага”-г хангаж ажиллахад бэлтгэж байна. Итгэмжлэлийн 12 төлөвлөгөөг гарган төвийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2.4 Хэмжих хэрэгсэл, хэмжлийн технологийн салбар:

1. Автомат станцуудад тогтмол хяналт тавин ажиллаж байна. Халхгол өртөөнд AWS-310 Автомат станц шинээр суурилуулан ажилд оруулаад байна.
2. Чойбалсан өртөөний Чийгийн мэдрүүр шинээр сольж чийг 100% давдаг байсныг янзлав цаашид Матад болон Дашбалбар өртөөний чийгийн мэдрүүрийг шинээр сольж хэвийн ажилд оруулна.
3. Чойбалсан өртөөний ажиглалтын талбайд хөрсний гүний MD-301 Автомат станцыг 0,20, 0,40 0,60 1,20 1,60 2,40 3,20м гүнд 7 ширхэг мэдрүүр байрлуулан ажилд оруулаад байна.
4. Халхгол өртөөний автомат станцын цагийн зөрүүг арилгуулж сайтын мэдээллийг хэвийн болгосон.
5. Матад өртөө болон Хөлөнбуйр харуулд ажиглалтын талбайн хашааг шинээр хийж байна.



TEAMVIEWER, ANYDESK программ ашиглан интернэтэд холбогдсон Онон өртөө 4, Дашбалбар 7, Матад өртөө 3, Халхгол өртөөнд 5 удаа холбогдож “**Персонамис**”, “**QFE даралт боддог программ**”, автомат станцын программд цагийн тохируулга хийж программын гэмтлийг засварлах сар бүрийн мэдээ мэдээллийг хүлээн авч ажиллаж байна.

Хэмжих хэрэгсэл:

Нэмэлт захиалгыг албан бичгээр ЦУОШГ-т 6 салбарт хэмжих хэрэгсэл болон дэвтэр хүснэгтийн захиалга хүргүүлэв.

Чойбалсан, Халхгол өртөөний хөрсний (5, 10, 20, 30, 50см-ийн) гүний чийг, температур хэмжих **EM-50 DATALOGGER** хөрсний мэдрүүрийг 3 дугаар сарын 1-нд ажилд оруулан сар бүрийн 1, 11, 21-нд мэдээллийг хүлээн авч дамжуулж байна. Чойбалсан өртөөнд ZL-6 хөрсний чийг температурын багаж шинээр суулгаж ажилд оруулсан. Халхгол өртөөний EM-50 даталогер хэвийн ажиллаж байна.



<http://119.40.97.101:8080/Cdpa/a?login> линкээр орж автомат станцын тоололтыг авч ажиллаж байна.

Стандарт хэмжил зүйн газраас улсын хэмжээнд ашиглаж байгаа хэмжих хэрэгслийн судалгаа гаргаж судалгааны хүрээнд байгууллагын хэмжээний тооллогоо хийж гүйцэтгэн Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторид хүргүүлэв.

Байгууллага дээр зохион байгуулсан сургалтуудад тогтмол хамрагдсан.

- 3 дугаар сард Гамшгаас хамгаалах бэлэн байдлын сургалтын бэлтгэл ажил хангасан.
- Аймгийн ЗДТГазраас зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т оролцсон.
- Байгууллага орчмын 50 метрийн цасыг цэвэрлэх ажлын хүрээнд засмал зам, явган хүний замын цасыг цэвэрлэсэн.

2.5 Архив мэдээллийн дэд сан:

Хөтөлбөрт тусгасан заавар, зөвлөмжийн дагуу төлөвлөсөн ажлыг алдаа хоцрогдолгүй биелүүлж ажиллалаа.

НЭГ. Архивд хийсэн ажлын талаар:

- Цаг уурын 5 өртөөд 10 харуул, хөдөө аж ахуйн цаг уур, мэдээлэл үйлчилгээний хэлтэс, байгаль орчны лаборатори, ус судлалын салбаруудаас 2024 оны анхан шатны цаасан суурьтай баримтыг хүлээн авч нийт 126 хадгаламжийн нэгж, 14544 хуудастай цаасан баримтыг хадгаламжийн санд байрлуулсан.

- Дашбалбар, Онон, Матад, Халхгол өртөөдийн өөрөө бичигчийн 2024 оны термограф, гигрограф, барографын туузан лентийг шалгаж 8 хадгаламжийн нэгж 1802 хуудастай цаасан баримтыг архивд байрлуулсан.
- Цаг уурын 5 өртөө 10 харуулын ХАА-н цаг уур, ус судлал, байгаль орчны лаборатори цаасан суурьтай материалыг шалгаж нийт 126 хадгаламжийн нэгж 14544 хуудас цаасан материалыг ADRSS программд шивж цахим сан үүсгэн 05 дугаар сарын 14-нд архив мэдээллийн сангийн хэлтэст FTP сүлжээгээр дамжуулан ажилласан.
- Халхгол, Матад, Дашбалбар, Онон өртөөдийн өөрөө бичигчийн лент болох гигрограф, термограф, барографын нийт 1136 ширхэг, 639MB хэмжээтэй цаасан баримтыг цахимжуулан цахим баримт үүсгэн архив мэдээллийн сангийн хэлтэст хүргүүлэн ажилласан.

Мэдээллийн дэд санд хийсэн ажлын талаар: Цаг уурын 5 өртөө 10 харуулын уур амьсгалын горимын мэдээ, шүүмж шалгалтыг хүлээн авч, “Цахим мэдээ хүлээн өгөх акт” үйлдсэн. Өртөө харуулаас нийт isx-75 tab-75, res-75, шүүмж шалгалт-5, 13.2mb хэмжээтэй файлыг хүлээн авч цахим сан үүсгэсэн.

Чойбалсан өртөөний нарны цацрагийн автомат станцын мэдээг хүлээн авч, тасалдлыг “AWS Tasaldal New” программаар шалган, протокол хөтөлж, цахим акт файлын тоо 323 , файлын хэмжээ 55.0 mb хүлээн авч цахим сан үүсгэсэн.

Цаг уурын автомат станцтай болох Чойбалсан, Халхгол, Матад, Дашбалбар, Онон өртөөд, Баяндун харуулын мэдээг хүлээн авч шалган акт протокол болон цахим акт үйлдсэн. Нийт автоматын станцын файлын тоо 1788, файлын хэмжээ 386 mb цахим сан үүсгэсэн.

Мэдээ, мэдээллийн үйлчилгээ: Цаг агаарын бодит мэдээгээр аж ахуйн нэгж, албан байгууллага, хувь хүмүүст нийт 17 мэдээгээр үйлчилсэн байна. Үүнээс төлбөргүй 6ш, төлбөртэй 11 мэдээ байна. Байгууллагын төрийн сангийн дансанд нийт 828500 төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна. Аж ахуйн нэгж албан байгууллага, хувь хүнд хүсэлтийн дагуу түргэн шуурхай үйлчилнэ.

2.6 Ус судлалын салбар:

Хөтөлбөрт шинжилгээний ажил: Усны гадаргын ууршилтын ажиглалт Цаг уурын “Чойбалсан” өртөө, “Халхгол” өртөө, Ус судлалын “Буйр –Загасны үйлдвэр” харуулуудад 5 дугаар сарын 1-ээс эхлэн, 186 удаагийн хэмжилт хийсэн.

Газрын доорх усны түвшний ажиглалтыг Улз-Баян-Уул, Улз-Дашбалбар, Хэрлэн-Чойбалсан станцуудад хөтөлбөрийн дагуу нийтдээ 150 удаа хийсэн.

Баяндун сумын Наранбулагийн ундаргын ажиглалт жилийн турш нийт 15 удаа хийгдсэн.

Жилийн урсцын эмхэтгэлийг 2024 оны 12 сараас эхлэн боловсруулж, 3 дугаар сарын 20-нд Гадаргын ус судлалын хэлтэст файлаар FTP сүлжээнд, цаасан материалаа шуудангаар илгээсэн.

Гулдиралын хэв гажилтын өөрчлөлтийн судалгааг 05 дугаар сарын 19-нд Хэрлэн гол дээр усны түвшин 105 см түвшинд хэмжилтийг хийсэн. Тус өртөө нь хөтөлбөрийн дагуу ус

судлалын 7, нуурын 2, гэрээт 1 харуулд усны түвшин ажиглалтын УД-1 дэвтэр 50 ш, усны өнгөрөлтийн УД-2 дэвтэр 84 ш, УД-7 дэвтэр 5 ш, нийт 139 ширхэг дэвтэр, хүснэгт хүлээн авч техник, шүүмж шалгалт хийсэн.

Ус судлалын харуулуудын тайланг сар бүрийн 18-20-нд ГУСХэлтэст FTP сүлжээгээр дамжуулсан. Өртөөний Х/б –100, А/Ч –100, Мэдээний ирц 99.8 хувь нэгдсэн дүнгээр 99.95 хувь дүнтэй дүгнэгдсэн байна. Мөсний зузааныг 1, 2, 3 саруудад 90 удаа хэмжсэн байна.

Мэдээ дамжуулалт, мэдээллийн ажил

<https://dornod.weather.gov.mn/> болон Дорнод аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв facebook хуудсанд Мөс цөмрөх аюулаас урьдчилан сэрэмжлүүлэх мэдээг 10 удаа, усны түвшний болон мөсний зузааны 10 хоногийн тойм мэдээ 14 удаа, хаврын шар усны үер болон уруйн үерээс сэрэмжлүүлэх мэдээ 4 удаа буюу нийт 28 удаа байршуулж, төр захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэдэд үйлчилж ажилласан. Фейсбүүкийн мэдээ нь 55324 иргэний хандалт авсан байна. Харуулын техникч нар тухайн орон нутагтаа мэдээ, мэдээллээр үйлчилж ажилласан байна.

8 харуулын мөсний үзэгдэл зузааны 10 хоногийн 72 мэдээ, өдөр бүрийн усны түвшний 488 мэдээ харуулуудаас хүлээн авч шалган 192.168.100.13/currentweather вэб сайтаар дамжуулсан. Мэдээ дамжуулалт 99.8 хувьтай дүгнэгдсэн.

Сар тутмын УХШ -1 тайланг 4 удаа дамжуулж, УХШ-1 тайлангийн дүн 99.95 хувьтай дүгнэгдсэн байна.

Архив, мэдээллийн сан

Рэки рэжим программд жилийн усны түвшин, усны өнгөрөлт, ус, агаарын температур, хур тунадасны шивэлт бүрэн хийгдсэн.

Шалган туслах ажил

Хаврын шалган туслах ажлыг 4 дугаар сарын 30-нд Улз-Дашбалбар харуулд, 5 дугаар сарын 09-12-нд Халх-Сүмбэр, Нөмрөг-Хилийн застав, Халх-Баянхошуу, Буйр-Загасны үйлдвэр харуулуудад, 5 дугаар сарын 7-нд Хэрлэн-Чойбалсан харуул хийж дуусгасан болно. Ус судлалын 6 харуулд шалган туслах ажлыг хийснээс хангалттай 4, хэвийн 2 байна.

Багаж, тоног төхөөрөмж, Хангалт

№	Харуулын нэрс	Усны гутал	Секунд омер	Өвлийн ажлын хувцас	Духны гэрэл	Борооны цув	Усны термометр /TP300/	Эсгий оймс	Цагаан будаг /л/
1	Хэрлэн-Чойбалсан	1		1	1	1	1	1	5
2	Хэрлэн-Хөлөнбуйр	1		1	1	1	1	1	12
3	Халхгол-Сүмбэр	1	1	1	1	1	1	1	5
4	Улз-Эрээнцав	1		1	1	1	1	1	2
5	Улз-Баян-Уул	1		1	1	1	1	1	2
6	Буйр-Загасны үйлдвэр	1		1	1	1	1	1	15
7	Нөмрөг-Хилийн застав	1		1	1	1	1	1	2

8	Улз-Дашбалбар	1		1	1	1	1	1	2
9	Хөх нуур-37-р зөрлөг	1		1	1	1	1	1	2
10	Халх-Баянхошуу	1		1	1	1	1		2
11	Өртөөнд	10		2					

Шинэлэг санаа, хэрэгжүүлсэн арга хэмжээ

Буйр–Загасны үйлдвэр харуулын ажиглагч Ц.Мөнхдалай нь харуулын хашаа, репер шонгуудаа будаж, сэргээсэн. Харуулын хаяг шинээр хийж, хамгаалалтын хүрээ анхааруулга самбар шинээр хийж байршуулсан.



1. МЭДЭЭЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ:

Урьдчилан мэдээлэх салбар:

1. Бүх төрлийн мэдээний таарц оночийг бататгах, ахиулах
2. Погод мэдээ зохиолт, дамжуулалтын алдааг орон нутгийн техникч нартай хамтран бууруулах
3. Инженер, техникчийн ажлыг сайжруулах
4. Климат, аюул агаар мэдээний чанарыг бататгах
5. Мэдээ, мэдээллийг ард иргэдэд цахимаар хурдан шуурхай хүргэх

1. УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЭХ САЛБАР

Мэдээлэл, үйлчилгээ :

- 10 хоногийн төлөв 26 удаа, тойм 186 удаа
- Сарын урьдчилсан мэдээ 6 удаа
- Улирлын төлөв 26 удаа
- Түймрийн эрсдэлийн хуурайшлын зэрэг 83 удаа
- Цаг агаарын анхааруулга мэдээ 36 удаа
- Бүх сумдын нутгаар нарийвчилсан, 1 хоног, 5 хоногийн урьдчилсан мэдээ тус тус 365 удаа
- Дорнод аймгийн нутгаар бүх төрлийн цаг агаарын урьдчилсан мэдээг видео хэлбэрээр 365 удаа гаргасан.

- Малчид, тариаланчид, иргэдэд цаг агаарын болон хуурайшилтын анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээ нийт 84 удаа давхардсан тоогоор 23804 иргэний гар утсанд мессежээр хүргэсэн байна.
- Himawary, FY-2, NOAA –ын хиймэл дагуулын бүтээгдэхүүнээс үүлний зургийг өдөр бүр цаг агаарын урьдчилсан мэдээ зохиолтод болон цаг агаарт зориудаар нөлөөлөх, иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангахад авч ашиглаж байна.
- Сэрэмжлүүлэх мэдээ нарийвчилсан 6 удаа, хоног 8 удаа дамжуулсан. Нийт 14 удаа: Үүнээс Их цас 3 удаа, Цасан шуурга 3 удаа, Хүчтэй салхи 3 удаа тус тус зохиосон.
- Цаг уур, орчны шинжилгээний Газрын 2023 оны 12 дугаар сарын 14 өдрийн A/257 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Урьдчилан мэдээлэх салбарын шинжилгээний ажлын дүн 2025 оны эхний хагас жилд Системдээ 1 дүгээр байранд орсон.

Он, сар	Нарийвчилсан мэдээ		Хоногийн мэдээ		5 хоног мэдээ	Аюул, агаар		Климат	УСМ, СМ-ийн таарц	УСМ, СМ-ийн онч	АУ, ГҮ-ийг урьдчилан илрүүлсэн байдал	Ерөнхий дүн
	ирц	таарц	ирц	таарц	таарц	ирц	чанар					
2024	99.7	97.6	99.7	96.1	92.9	100	100	100	95.0	100	98.3	98.9
2025	100	97.5	100	97.3	94.5	100	100	99.9	100	100	100	99.5
Ахиц	0.3	-0.1	0.3	1.2	1.6	-	-	-0.1	5.0	-	1.7	0.6

1. Урьдчилсан мэдээний ирц, чанар: Чойбалсан хотын хагас хоногийн мэдээний ирц 100 хувь өмнөх оны ирцээс 0.3 хувиар ахисан, 1 хоногийн мэдээний ирц 100 хувь өмнөх оны ирцээс 0.3 хувиар ахисан, хагас хоногийн мэдээний таарц 97.5 хувь өмнөх оноос 0.1 хувиар буурсан, 1 хоногийн мэдээний таарц 97.3 хувь өмнөх оноос 1.2 хувиар ахиу, 5 хоногийн мэдээний таарц 94.5 хувь өмнөх оноос 1.6 хувиар ахиу байна.

2. Климат мэдээний ирц, чанар: Климат мэдээний ирц, чанар 99.9 хувь буюу өмнөх оноос 0.1 хувиар буурсан байна.

3. Аюул агаар мэдээний ирц, чанар: Аюул агаар мэдээний ерөнхий ирц 100 хувьтай, чанар 100 хувьтай байгаа нь өмнөх оны хагас жилтэй харьцуулахад ижил байна.

4. Аюултай үзэгдэл, гамшигт үзэгдлийн урьдчилан мэдээлсэн байдал: Сэрэмжлүүлэг, урьдчилан сэргийлэх мэдээний таарц 100 хувь, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.0 хувиар ахисан, онч 100 хувь өмнөх оны мөн үетэй тус тус ижил байна. Ерөнхий дүнгээр 100 хувь буюу өмнөх онтой ижил байна.

2024 оны 12 сараас 2025 оны 05 дугаар сард Дорнод аймгийн нутгаар ажиглагдсан цаг агаарын аюултай үзэгдлийн хүснэгт сум тус бүрээр

	хүчтэй салхи	цасан шуурга	шороон шуурга	орон шуурга	цас	нойтон цас	нөөлөг салхи	Мөндөр	түймэр	зузаан цас, нягт	ширүүн аадар бороо	хуурай халуун салхи	агаарын даралтын өөрчлөлт	цанталт	хүйтэн бороо	Өртөө, харуул дээрх газар хөдөлсөн	Голын үер	нийт
Чойбалсан	1			8		5												14
Дашбалбар	24			6		4							1					35
Халхгол	10			18		14							1					43
Матад	21			15		4			1				1					42
Баян-Уул	6			2	1		1											10
Баяндун	3			5		2												10
Баянтүмэн				4		1			2									7
Булган	1			4		1												6
Гурванзагал	8			5		1												14
Сэргэлэн	2			4		2			1									9
Халхгол-Ялалт баг	3			10		10			1									24
Хөлөнбуйр				3					1									4
Цагаан-Овоо				3														3
Чулуунхороот	3			5		2												10
Хэрлэн	1			6		2												9
НИЙТ	83	0	0	98	1	48	1	0	6	0	0	0	3	0	0	0	0	240

Энэ оны нийт цаг агаарын аюул мэдээ нийт 240 удаа зохиож дамжуулсан байна. Хамгийн их нь Орон шуурга 98 удаа, хүчтэй салхи 83 удаа, нойтон цас 48 удаа, түймэр 6 удаа, агаарын даралтын өөрчлөлтөөр 3 удаа, нөөлөг салхи 1 удаа, их цас 1 удаа тус тус ажиглагдсан байна.



Зураг 1. 2024 оны 12 дугаар сараас 2025 оны 05 дугаар сард ажиглагдсан аюул агаар мэдээний төрөл, ажиглагдсан аюул агаар мэдээний төрөл /сум тус бүрээр/

Хэрэглэгчдэд үйлчилсэн байдал: Дээрх бүх төрлийн урьдчилсан ба тойм мэдээг аймгийн ЗДТГ, ОБГ, бүх сумд, телевизүүд болон бусад гэрээт газрууд, албан байгууллагуудад болон иргэдэд <http://s.dornod.weather.gov.mn> вэб сайт, имэйл, мессенжер, Callpro болон масс мессеж үйлчилгээгээр, хэвлэмэл байдлаар, товхимол,

зураглалын хэлбэрээр мөн сумдын цаг уурын техникч нараар дамжуулан сумдын удирдлагуудад хүргэхээс гадна email болон Facebook олон нийтийн сүлжээнд байршуулан ажилласан. Үүнд

1. 1 болон 5 хоногийн цаг агаарын урьдчилсан мэдээ 186 удаа, өнгөрсөн 10 хоногийн цаг агаарын тойм, усны түвшний мэдээ, агаарын чанарын мэдээ тус бүр 26 удаа, малчид, иргэдэд зориулсан цаг агаарын Урьдчилан сэргийлэх болон гамшигт үзэгдлийн мэдээ 4 удаа, Сэрэмжлүүлэг мэдээ 14 удаа, анхааруулга мэдээг нийт 36 удаа автомат хариулагч бүхий утсанд нийт 186 удаа мэдээ, мэдээлэл байршуулан ажилласан.



2. <http://s.dornod.weather.gov.mn> сайтад өдөр бүр цаг агаарын нарийвчилсан мэдээ 1, 5 хоногийн урьдчилсан мэдээг текст болон зурган хэлбэрээр 372 удаа, даваа гараг бүр 10 хоногийн урьдчилсан мэдээ 26 удаа, улирлын төлөвийн мэдээ 7 удаа, сарын төлөв 6 удаа, анхааруулга, сэрэмжлүүлэг 50 удаа байршуулсан. Энэ хаягаас аймгийн төвийн 5 телевиз цаг агаарын мэдээг татан авч өдөр бүр ард иргэдэд мэдээлж байна. Мөн цаг үеийн байдлын талаар болон урьдчилсан мэдээний талаар 3 удаа яриа өгсөн байна.

3. Дорнод аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв байгууллагын page хуудсанд анхааруулах болон сэрэмжлүүлэх мэдээ, цаг агаарын нарийвчилсан мэдээ, 10 хоног болон сар, улирлын төлөв текст, зурган, видео хэлбэрээр нийт 750 мэдээ, мэдээлэл байршуулж давхардсан тоогоор 771108 иргэн мэдээлэл авсан хандалттай байна.

4. “Багц мессеж” үйлчилгээ:

Зорилго: Цаг агаарын аюултай үзэгдлийн болон болзошгүй аюул гамшгаас урьдчилан сээрэмжлүүлэх, малчид иргэдийн гар утсанд түргэн шуурхай багц мессеж илгээх.

Дорнод аймгийн УЦУОШТ-ийн Урьдчилан мэдээлэх салбараас Чойбалсан хот болон Гурванзагал, Халхгол сум, Ялалт баг, Матад, Баянтүмэн, Булган, Чойбалсан сумдын иргэдэд багц мессеж хүргэж ажиллаагүй модем гэмтэлттэй тул цахим хаягуудаар мэдээлэл хүргэж ажилласан.

Дорнод аймгийн нутгаар 2025 оны хагас жилийн багц мессеж дамжуулсан бүртгэл

Д/д	Сумдын нэрс	Мессеж илгээсэн давтагдлын тоо	Нэг удаа мессеж явуулдаг хүний тоо	Мэдээ хүлээн авсан хүний тоо	Модемын сунгалт
1.	Чойбалсан хот	-	-	Модем гэмтэлттэй тул цахимаар мэдээлэл хүргэсэн	Сунгалтыг УЦУОТөвөөс хийдэг.
2.	Дашбалбар сум	6 удаа	365	2190 иргэнд	ЗДТГ-аас сунгалт хийгддэг.
3.	Баян-Уул сум	4 удаа	233	926 иргэнд	ЗДТГ-аас сунгалт хийгддэг.
4.	Баяндун сум	4 удаа	266	1084 иргэнд	ЗДТГ-аас сар бүр гарсан төлбөрийг төлдөг.

5.	Халхгол сум, Ялалт баг	-	-	Модем гэмтэлтэй тул цахимаар мэдээлэл хүргэсэн	УМС-аас илгээдэг.
6.	Матад сум	-	-	-	УМС-аас илгээдэг.
7.	Цагаан-Овоо сум	-	-	ЗДТГ-аас Модемоо буцааж авсан	сумын ЗДТГ-аас 150000 төгрөгийн сунгалт хийлгэдэг
8.	Сэргэлэн сум	8удаа	328	1520 иргэнд	ЗДТГ-аас сар бүр 9000 төгрөгийг цэнэглэдэг. Багуудын сүлжээ ашиглан олон нийтийн сүлжээгээр хүргэж байна
9.	Гурванзагал сум	-	-	Модем гэмтэлтэй тул цахимаар мэдээлэл хүргэсэн	УМС-аас илгээдэг.
10.	Хөлөнбуйр сум	5 удаа	212	1060 иргэнд	ЗДТГ-аас сунгалт хийгдсэн
11.	Булган сум	-	-	Модем гэмтэлтэй тул цахимаар мэдээлэл хүргэсэн	сумын ЗДТГ-аас 150000 төгрөгийн сунгалт хийлгэдэг
12.	Баянтүмэн сум	-	-	Модем гэмтэлтэй тул цахимаар мэдээлэл хүргэсэн	ЗДТГ-аас 1 жилээр сунгалт хийж өгсөн.
13.	Чойбалсан сум	-	-	Модем гэмтэлтэй тул цахимаар мэдээлэл хүргэсэн	УМС-аас илгээдэг.
14.	Чулуунхороот сум	10удаа	110	1133иргэнд	2024 онд 120000 төгрөгийг сумын ЗДТГ- аас гаргасан
Нийт			1514иргэн	7913 иргэнд	

Илгээж буй мэдээ их хэмжээтэй бол хоёр хуваагдан очдог ба тухайн мэдээ цаг алдалгүй шуурхай илгээгдэж, иргэдийн гар утсанд хүрдэг онцлогтой юм.

2025 оны хагас жилд давхардсан тоогоор нийт 7913 иргэний гар утсанд мессеж илгээж, нийт 395,650 төгрөгийн нэгж зарцуулсан байна.

5. Мөн нээлттэй утас 70583178, 70583000 дугаарт хандсан 1500 иргэнд шуурхай мэдээлэл хүргэсэн.

6. 2025 оны 3 дугаар сарын 24-нд Мөн Дэлхийн усны өдрийг угтан зохион байгуулсан “НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ”-ийг БОГ-тай хамтран хүрээнд байгууллагын танилцуулж ажилласан.

Үүнд: Төрийн албан хаагчид, ард иргэдэд цаг агаарын 10 хоногийн, сар, улирлын урьдчилсан мэдээнүүдийг цаасан хэлбэрээр танилцуулан, санал хүсэлт хүлээн авсан.

Погод мэдээ дамжуулалтын дүн: 2024 оны 12 дугаар сар, 2025 оны 01 дүгээр сараас 05 сард 5 өртөө тус бүр 1456, 10 харуул 546 удаа, шинжилгээний хөтөлбөрт ажил тасралтгүй нийт 12740 погод мэдээг 186 хоногт дамжуулсан байна. Үүнээс шалтгаангүй тасалсан 90, интернэт тасарсан байхгүй, утасны сүлжээ тасарсан 6, төхөөрөмж гэмтэлтэй 2, дахин

дамжуулсан 22 погод мэдээ, цахилгаан болон амарснаас шалтгаалсан хоцрогдолгүй. Нийт 120 погод мэдээ хоцорсон байна. Мэдээ дамжуулалтын чанарыг дараах хүснэгтэд үзүүлэв. 2025 оны хагас жилийн төвийн дүнгээр өртөөдөөр 99.96 хувь өмнөх оноос 0.3 хувиар ахиу, бүх сумдаар 99.1 хувь буюу өмнөх оны дүнтэй адил байна. Өртөөнөөс Халхгол өртөө хамгийн их буюу 27 удаа, Дашбалбар 13 удаа, Матад 12 удаа, Онон өртөө 6 удаа, Чойбалсан хамгийн бага 5 удаа, харуулаас хамгийн их Баянтүмэн 12 удаа, Хөлөнбуйр, Чулуунхороот сумдад 10 удаа, бусад харуул нь 1-9 удаа мэдээ хоцорсон болон дахин дамжуулсан байна.

Погод мэдээ дамжуулалтын ирцийг байруудаар авч дүгнэвэл:

- Өртөөнөөс I байранд Чойбалсан, II байранд Онон III, байранд Матад,
- Харуулаас I байранд Халхголын Ялалт баг, II байранд Сэргэлэн, Баяндун, Цагаан-Овоо III байранд Булган тус тус дүгнэгдэж байна.

Дугаар	Аймгийн нэр	Станцын нэр	Станцын индекс	Шалт-гүй	Инт. тасарсан	Утас, сүлж. тасарсан	Утас, хуга. алдсан	Төх. гэмтэлтэй	Дах. дамжуулсан	Цах. тасарсан	Өвчтэй	Амарсан	Нийт хоцорсон	Нийт өдөр	хувь
1	Дорнод	Онон	255	5	0	0	0	0	1	0	0	0	6	1456	99.6
2	Дорнод	Дашбалбар	256	6	0	4	0	0	3	0	0	0	13	1456	99.1
3	Дорнод	Чойбалсан	259	5	0	0	0	0	0	0	0	0	5	1456	99.7
4	Дорнод	Халхгол	313	21	0	1	0	2	3	0	0	0	27	1456	98.1
5	Дорнод	Матад	314	10	0	0	0	0	2	0	0	0	12	1456	99.2
6	Дорнод	Баяндун	636	0	0	0	0	0	2	0	0	0	2	546	99.6
7	Дорнод	Баянтүмэн	637	9	0	0	0	0	3	0	0	0	12	546	97.8
8	Дорнод	Хэрлэн	638	8	0	0	0	0	1	0	0	0	9	546	98.4
9	Дорнод	Булган	639	3	0	0	0	0	1	0	0	0	4	546	99.3
10	Дорнод	Гурванзагал	640	3	0	0	0	0	2	0	0	0	5	546	99.1
11	Дорнод	Сэргэлэн	641	1	0	0	0	0	1	0	0	0	2	546	99.6
12	Дорнод	Халхгол	642	1	0	0	0	0	0	0	0	0	1	546	99.8
13	Дорнод	Хөлөнбуйр	643	9	0	0	0	0	1	0	0	0	10	546	98.2
14	Дорнод	Цагаан-Овоо	644	1	0	0	0	0	1	0	0	0	2	546	99.6
15	Дорнод	Эрэнцав	645	8	0	1	0	0	1	0	0	0	10	546	98.2
	нийт			90	0	6	0	2	22	0	0	0	120	12740	99.0
	өртөө			47	0	5	0	2	9	0	0	0	63	7280	99.1

Түймрийн эрсдэлийг хуурайшлын зэрэглэлийн мэдээллээр үнэлгээ хийсэн байдал:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 153 дугаар зарлигийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 1.4-т заасныг хэрэгжүүлэн, ой, хээрийн гал түймрийн эрсдэл өндөртэй бүс нутагт гал түймрээс урьдчилсан сэргийлэх хяналтын нислэг үйлдэхэд шаардлагатай нислэгийн цаг уурын мэдээ, мэдээллээр хангах, Засаг даргын 2024 оны 01 дүгээр албан даалгаврын хүрээнд Тус төвийн урьдчилан мэдээлэх салбараас 2025 оны 03 дугаар сарын 15-наас 06 дугаар сарын 20-нийг хүртэл, 09 дүгээр сарын 20-ноос 10 дугаар сарын 31-нийг хүртэл Дорнод аймгийн бүх сумдын 14 цагийн агаарын болон шүүдэр цэгийн температураар хуурайшилтын зэрэглэлийг бодож, хүснэгт болон текст хэлбэрээр 83 удаа боловсруулж Дорнод аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн фэйж хуудсанд 83 удаа байршуулж, 59420 иргэдийн хандалттай байна. Мөн ОБГ, ХХААГ, БОАЖГазар болон

сумдын цаг уурын өртөө харуулын техникч нараар дамжуулан сум, орон нутгийн удирдлагуудад өдөр бүр тогтмол хүргүүлж ажилласан.

Климат мэдээ зохиолт, дамжуулалтын дүн: 2025 оны хагас жилийн дүнгээр энэ онд Климат мэдээ зохиолт бүх өртөө 99.9 хувьтай дүгнэгдэж дамжуулсан байна.

2. НИСЛЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Зорилго:

- Нислэгийг цаг агаарын бүх төрлийн урьдчилсан болон бодит мэдээ мэдээллээр шуурхай үйлчлэх
- ТАФ мэдээний таарцыг дээшлүүлэх
- Синоптик инженерийн мэдээ дамжуулалтын шивэлтийн алдааг багасгах
- Нисэхийн техникчдийн мэдээ дамжуулалтын шивэлт, зааврын алдааг багасгах
- Синоптик инженерийн мэргэшил, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах
- Синоптик инженерийн нислэгийн цаг агаарыг 52 мэдээгээр үйлчлэх эрхийн гэрчилгээг сунгуулах
- Цаг агаараас шалтгаалсан нислэгийн саатал, зөрчилгүй ажиллах

Мэдээлэл үйлчилгээний тоо: Хагас жилийн байдлаар

- Үйлдсэн үндсэн нислэг 35 нислэг, 11 чиглэлийн урьдчилсан мэдээ Үүнд: Захиалгат 6 удаа, онцгой үүрэг 1 удаа, түргэний нислэг 5 удаа, тусгайд үүрэг 1 удаа, хувийн нислэг 2 удаа, дадлага сургалтын нислэг 5 удаа, шалган туслах 1 удаа тус тус явагдсан.
- Орон нутгийн бэлтгэл буудлын нислэгт-5
- Буудал орчмын бодит мэдээ-117
- Spesi мэдээ-4
- Буудал орчмын урьдчилсан мэдээ-46
- Аэродромын район-23
- Нислэгийн чиглэлийн урьдчилсан мэдээ /Ни-5/- 11
- Аэродромын урьдчилсан мэдээ 23
- Хөөрөлтийн урьдчилсан мэдээ-36
- Харьцуулсан ажиглалт-12
- 7 хоногийн урьдчилсан мэдээ-26
- Цаг агаарын зөвлөгөө 12
- Ням гараг бүр “Чойбалсан НБ”-ын 7 хоногийн урьдчилсан мэдээг 26 удаа нислэгийн цаг уурын төвийн FTP-д дамжуулж, google.drive-д байршуулж, нислэгийн удирдагчид танилцуулсан.

Үйлчилсэн нислэг, цаг агаарын бодит болон урьдчилсан мэдээний тоо

Сар	2024/12	1	2	3	4	5	нийт
Үндсэн	1		5	4	9	16	35
Бэлтгэл нисэх буудлаар			1		1	3	5
METAR	8		14	14	30	51	117
SPECI					2	2	4
TAF	3		6	6	12	19	46
TAF TOIM			6	6	7	12	31
Район	2		4	4	6	10	16
Чиглэлийн урьдчилсан мэдээ				2	4	5	11
Угталтын урьдчилсан мэдээ			2	2	2	7	13
Суултын урьдчилсан мэдээ							0
Аэродромын урьдчилсан мэдээ	2		4	4	8	8	23
Аэродромын сэрэмжлүүлэг мэдээ							0
Хөөрөлтийн урьдчилсан мэдээ	1		6	6	9	14	36
AIRMET мэдээ							0
Агаарын хөлгийн ажиглалтын мэдээ							0
Харьцуулсан ажиглалт	2		2	2	2	2	12
7 хоногийн урьдчилсан төлөв	5	4	4	5	4	4	26
Цаг агаарын зөвлөгөө			4	4	4	WQ	12

2025 оны нийлүүлсэн бүтээгдэхүүнийг графикаар үзүүлэв.



2024 онд "Чойбалсан" нисэх буудалд нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо

Буудал орчмын урьдчилсан мэдээний таарц 97.4 хувь буюу өмнөх оноос 0.5 хувиар ахисан, мэдээ зохиолтын чанар 97.6 хувь буюу өмнөх оноос 6.8 хувиар ахисан, шуурхай үйлчилгээ 100 хувь буюу өмнөх он мөн үетэй адил, бол шуурхай зохицуулалт 100 хувь дүгнэгдэж нислэгийн үйлчилгээний ерөнхий дүн 99.5 хувьтай буюу өмнөх оноос 4.1 хувиар ахисан байна. Ажил дүгнэх журам шинэчлэгдээгүй тул байр эзлүүлээгүй байна.

Тоног төхөөрөмж, сүлжээ: НЦУТ болон аймгуудтай FTP протокол болон <http://amc.namem.gov.mn/> хаягаар мэдээ, мэдээллээ солилцон ажиллахын зэрэгцээ "Чойбалсан НБ"-тай утсаар харилцан заавар, зөвлөмжийг тухай бүр өгч нислэгийн цаг агаарын мэдээний хяналтыг хийсэн. Зөвхөн нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчлэх эрхийн гэрчилгээтэй инженер, техникч нар <http://amc.namem.gov.mn/mds/> хаягаар интернэт орчинд өөрийн IP хаягаар нэвтэрч мэдээ, мэдээллээ дамжуулсан, нисэхийн техникчид AMHS хаягаар дамжуулан бусад аймгуудын METAR болон TAF мэдээг хүлээн авч байна.

Нислэгийн саатал: 2025 онд Нислэгийн саатал байхгүй

Хяналт шалгалт: 2025 оны 6 дугаар сарын 09-нөөс шалгалт хийгдэнэ.

- Нисэхийн техникчдийн METAR мэдээ зохиолт болон НИ-5, НИ-4, НИ-3, НИ-2 дэвтрүүдийн бичилтийг шалгаж, 2 удаа хариу зааварчилгаа өгч ажиллав.
- Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн нислэгийн цаг уурын үйлчилгээний ажлын байрны үйл ажиллагааны зааврыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.
- “Чойбалсан” нисэх буудал дахь цаг уурын AWS330 автомат станцын сунгалтын хугацаа 2024 оны 5 дугаар сарын 21-нд дуусаж, сунгалт 2025 оны 5 дугаар сарын 21-ний хүртэл сунгалт хийгдсэн.
- “Чойбалсан станц”-ын цаг уурын AWS310 автомат станцын хугацаа 2024 оны 9 дүгээр сарын 20-нд дуусаж, 2025 оны 9 дүгээр сарын 20-нийг хүртэл сунгалт хийгдсэн байна.
- “Чойбалсан станц”-ын цаг уурын AWS310 автомат станцын харьцуулсан тоололтыг сард 12 удаа нийт 12 удаа хийж төв рүү явуулан ажилласан.

Мэдээлэл үйлчилгээ: “Чойбалсан” нисэх буудлын нислэгийн удирдагчид цаг агаарын урьдчилсан мэдээний ам зөвлөгөө өгсөн.

Урьдчилан мэдээлэх салбараас гаргаж байгаа төрөл бүрийн урьдчилсан мэдээг тухай бүр татан авч мэдээллийн самбарт байршуулан нисэх буудлын удирдлага болон нислэгийн удирдагчдад танилцуулж үйлчиллээ.

Сургалт: “Нислэгийн цаг уур”-ын төвд нисэхийн цаг уурын бодит ажиглалтын мэдээний инженер, техникч нарт зориулсан давтан сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 07-ноос 11-нийг хүртэл дараах 5 өдрийн 40 цагийн сургалтад хамрагдаж, Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга Ж.Мөнхчимэг “Гэрчилгээ” авсан. Б.Очгэрэл 2025 оны 4 дүгээр сарын 22-ноос 5 дугаар сарын 06-ныг хүртэлх Нислэгт цаг агаарын урьдчилсан мэдээгээр үйлчлэх синоптик инженерийн анхан шатны 80 цагийн сургалтад хамрагдаж гэрчилгээ авч нислэгт үйлчлэх эрх авсан.


3. ЦАГ АГААРТ ЗОРИУДААР НӨЛӨӨЛӨХ

- **Зорилго:** Цаг агаарын зарим гамшигт үзэгдлийн байгаль экологи, улс орны эдийн засаг, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах зорилгоор цаг агаарын үзэгдэлд зориудаар зохистой нөлөөлөх үйл ажиллагаа явуулахад оршино.
- **Үндсэн чиглэл:**
 - ✓ Ой, тал хээрийн түймэр гарах эрсдэлтэй, хуурайшилт ихтэй газар нутагт эрсдэлийн зэргийг бууруулах
 - ✓ Хүн, техник хүрэх боломжгүй ой хээрийн түймрийг унтраахад дэмжлэг үзүүлэх
 - ✓ Бэлчээрийн болон газар тариалангийн бүс нутгийн хөрсний чийгийг нэмэгдүүлж ургамлын ургалтыг тэтгэх
 - ✓ Гадаргын усны түшинг нэмэгдүүлэх
 - ✓ Ган цөлжилтийг бууруулах.

2025 оны 05 дугаар сарын цаг агаарт зориудаар нөлөөлөх үеийн цаг агаарын нөхцөлийн тойм

Агаарын дундаж температур 10.4....13.8 градус байсан. Олон жилийн дундаж агаарын температуртай харьцуулахад Чойбалсан, Дашбалбар, Баян-Уул, Хөлөнбуйр сумдаар олон жилийн дунджийн орчим, Баяндун, Баянтүмэн, Булган, Гурванзагал, Сэргэлэн сумдаар олон жилийн дунджаас дулаан бусад сумдаар олон жилийн дунджаас хүйтэн байсан.Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бүх сумдаар 0.7-2.2 градусаар хүйтэн байна.

Агаарын үнэмлэхүй их /дулаан / +19...+35 / градус дулаан байсан ба хамгийн их утга /дулаан/ нь Дашбалбар, Сэргэлэн, Гурванзагал, Халхгол суманд +32...+35 градус, хамгийн бага утга нь / -4.....-8 / градус хүйтэн байсан ба Онон суманд -8 градус хүрсэн байна.



Хур тунадас: Аймгийн хэмжээнд бүх нутгаар 1-7 удаагийн давтамжтайгаар 0.9....18.9 мм хур тунадас орсон ба Олон жилийн дундаж хур тунадастай харьцуулахад Баян-Уул, Матад сумдаар олон жилийн дунджийн орчим, бусад сумдаар олон жилийн дунджаас бага хур тунадас орсон.Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Дашбалбар, Матад, Халхгол, Булган, Гурванзагал,Хөлөнбуйр сумдаар өмнөх оноос 5.8...15.0мм бага хур тунадас орсон.

Бэлчээрийн ургамал: Дорнод аймгийн нийт нутгаар бэлчээрийн ургамлын дундаж өндөр 5-13 см ба бэлчээрийн ургамлын ургалтын байдал Дашбалбар сумын нутгаар дунд зэрэг бусад сумын нутгаар хэвийн байна.



Хуурайшилтын зэрэглэлээр тооцоолсон түймрийн эрсдэлийн үнэлгээ:

2025 оны 05 дугаар сарын 15-ны байдлаар: Халхгол сум түймрийн аюул бага зэрэг (I зэрэг), Чулуунхороот, Матад, Халхгол сумын Ялалт багт түймрийн эрсдэл Нэн их, НЭН АЮУЛТАЙ (IV зэрэг), бусад нутгаар түймрийн аюул бага зэрэг (II зэрэг) болсон байна.

2025 оны 05 дугаар сарын 31-ний байдлаар: Халхгол суманд түймрийн аюул Бага (I зэрэг), Матад, Халхголын Ялалт багт түймрийн аюул Дунд зэрэг (II зэрэг) бусад сумдын нутгаар түймрийн эрсдэл Нэн их, НЭН АЮУЛТАЙ (IV зэрэг) хүрсэн байна.



Ажиллагаа 1: Онон бороо 1 экспедиц 05 дугаар сарын 12-ноос 13-нд шилжих шөнө Дорнод аймгийн Баян-Уул сумаас баруун зүгт 30км-т Хэнтий аймгийн Норовлин сумын түймэр Цагаан-Овоо, Баян-Уул суманд дэгдэхээс сэргийлж, дэмжлэг үзүүлэх зорилгоор Аймгийн Онцгой байдлын газартай хамтран үйл ажиллагаа зохион байгууллаа.


Үр дүн: 13-ны өдрийн 08 цагийн байдлаар: Чойбалсан хот, Баян-Уул, Баяндун сумдын нутгаар 11.0-17.0мм, Баянтүмэн, Булган, Цагаан-Овоо сумдад тус тус 9.0 мм, Дашбалбар, Гурванзагал, Чулуунхороот, Сэргэлэн, Хөлөнбуйр, Чойбалсан сумдад 0.1-7.0 мм бороо орж, хуурайшилт буурсан байна.

Аэросиноптик нөхцөл: Байгаль нуурын баруун тал 12-ны 20 цагийн төвийн даралт нь 532 гПа зурагдаж байсан бага даралтын орон 15-ны 08 цагт Монгол орны баруун хойд хэсэгт Дорнод аймгийн хойгуур 5 гПа болж шилжин орж ирж, Дорнод аймгийн нутаг бүхэлдээ уг цоклоны нөлөөнд байна. Энэ үед салхи ихтэй, манай нутгаар өндрийн салхи баруун, баруун хойноосоо 10-30 км/ц, газартаа салхи хойноос 5-10 м/с хүрэхээр байв.

Прогноз: Баруун хойноос чиглэлтэй үүлний масс орж ирэх үед салхи харьцангуй тогтвортой, ихэнх нутгаар хэсгээр орохоор харагдаж байв. Анализ хийхэд 13-ны өдөр салхи сэрэмжлүүлэг мэдээний хэмжээнд хүрэхгүй.

Ажиллагаа 2: Онон бороо 1 экспедиц 05 дугаар сарын 13,15-ны өдрүүдэд Халхгол сумаас баруун зүгт 60 км-т Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаа зохион байгууллаа.

Үүний үр дүнд 15-ны өдрийн 08 цагийн байдлаар: Матад сумдад 0.0-0.7мм, Халхголын сав нутгаар 5.0-9.0мм бороо орлоо



Цаг уурын холбоо, сүлжээний үйлчилгээ

НЭГ. Систем сүлжээ, компьютер тоног төхөөрөмжид хийгдсэн ажлын талаар:

- Халхгол, Баян-Уул өртөө, Булган, Баянтүмэн харуул, Ахлах техникч Балжид, Лабораторийн техникч Ж.Гэрэлтуяа нарын компьютерын системийг шинэчилж, шивэлтийн программ “PERSONA WIN” “VAISALA” болон бусад шаардлагатай хэрэглээний программуудыг суулгаж ажлын бэлэн байдалд оруулсан.
- Цаг уурын шивэлтийн PERSONAWIN программ шинэчлэгдэж ирсэнтэй холбогдуулан 10 харуул, 4 өртөөнд ANYDESK программ ашиглан шинэчлэн суулгасан.
- “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийн хэрэгжилтийг хангах, 2025 оноос төрийн албан хаагчид албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах бэлтгэл ажлын хүрээнд төвийн албан хаагчдын компьютерт монгол бичгийн фонт суулгаж монгол бичгээр албан хэрэг хөтлөх боломжоор хангасан.
- Архив мэдээллийн сангийн ерөнхий технологич Х.Отгонцэцэгийн компьютерт архивын түүврийн программ, шинээр хуваарилагдан ирсэн хувиргагч төхөөрөмжийг суулган тахиулж ашиглах заавар зөвлөгөө өгч ажилласан.
- Булган, Сэргэлэн, Баянтүмэн харуулын компьютерт шивэлтийн болон хэрэглээний программ мөн масс мессеж дамжуулах программыг тус тус суулгаж хүлээлгэн өгсөн.
- 70583178, 70583087 дугааруудад гарсан саатал гэмтлийн шалтгааныг тогтоолгож, хэвийн ажиллагаанд оруулсан.
- Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем ERP-д байгууллагын албан хаагчдын бүртгэлийг оруулж, албан хэрэг хөтлөх, ирцээ бүртгүүлэх боломжоор ханган ажиллаж байна.
- Интернэтийн хурданд өдөр бүр хяналт тавьж хэмжилт хийж, интернэтийн хурд хангалтгүй удаан тохиолдолд шалтгааныг тодорхойлон интернэтийн үйлчилгээ үзүүлэгч TOPNET компанид нийт 5 удаагийн шаардлагыг тавьж саатал гэмтлийг арилгуулан ажилласан.
- Байгууллагын утасгүй сүлжээний төхөөрөмжийг нэмэгдүүлж албан хаагчдад хүртээмжтэй байхаар байршуулсан.
- Melisigth360 камерын хэвийн ажиллагаанд өдөр бүр хяналт тавин ажиллаж байна.
- Албан хаагчдын компьютерын тоос шороог цэвэрлэх, хэвийн ажиллагааг хангах зорилгоор жижиг тоос сорогчтой болсон бөгөөд одоогоор 7 албан хаагчдын компьютерын тоос шороог цэвэрлэсэн.

- Албан хаагчдын компьютерт, принтер, тоног төхөөрөмжид гарсан саатал гэмтлийг тухай бүрд нь шуурхай арилган ажиллаж байна.

ДҮГНЭЛТ

2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтэд 4 зорилт, 74 арга хэмжээ төлөвлөснөөс 72 арга хэмжээний үр дүнд хүрсэн үзүүлэлттэй 86.2 хувьтай тайлагнасан. Салбаруудын шинжилгээний хөтөлбөрт ажил хэвийн явагдаж байна.

2025 оны 1 дүгээр улиралд 66 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж баталсан. Албан хаагчдын цалинд ажилласан жилийн нэмэгдэл 69,693.2 мянган төгрөг, мэргэшлийн зэрэг нэмэгдэлд 34,884.8 мянган төгрөг, ур чадварын нэмэгдлийг 39,879.9 мянган төгрөгийг цалингийн төсвөөс зарцуулаад байна.

Ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор борооны ус нэвчиж, гоожин, ажиллах нөхцөл хүнд байсан тул байгууллагын дээврийн 360 м.кв талбайн засварыг хийж дуусгасан. Мөн байгууллагын гадаад үзэмжийг сайжруулахад анхаарч, үүдний гадна фасадыг шинээр хийж, засварласан. Тоног төхөөрөмж урсгал засварын зардалд Нийт 33,0 сая төгрөг зарцуулсан.

Давхардсан тоогоор байгууллагын 136 албан хаагч сургалтад хамрагдсан бөгөөд үүнээс эрэгтэй албан хаагч 29, эмэгтэй 107 албан хаагч байна. Удирдах албан тушаалтан 9 удаа, гүйцэтгэх 127 удаа сургалтад хамрагдсан байна.

Албан хаагчдын ажлын байрыг баталгаажуулах зорилгоор МУИС-ын зүүн бүсийн сургуульд Цаг уурын анги нээлгэх хүсэлт гарган 9 албан хаагчийг элсэн ороод байна. Цаашид мэргэжлийн боловсон хүчний нөөцийг нэмэгдүүлэх бүрэн боломжтой болсон.

Хагас жилд Матад өртөө болон Хөлөнбуйр харуулд ажиглалтын талбайн хашааг шинэчлэх ажил хийгдэж байгаа ба цаашид бусад өртөө харуулын ажиглалтын талбайн хашааг шинэчлэх ажлыг төлөвлөн ажиллаж байна.

САНАЛ ХҮСЭЛТ

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАРТ

1. Тус төвийн конторын барилга 1974 онд ашиглалтад 51 дэх жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч барилгын дээвэр бүрэн хуурсан, урд нүүрийн хана цууралт өгснөөс өнгөрсөн зуны бороонд ажлын 4 өрөө усанд автсан. Үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй нөхцөл байгаа тул шинэ барилгатай болох нэн шаардлагатай байна.
2. Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицийн тоог нэмэгдүүлэх
3. Автомашин
4. Хөдөө аж ахуйн цаг уурын инженер болон ахлах техникчийн компьютер 2014 оноос ажиллаж эхэлсэн. Хүчин чадал нь муудсан тул солих шаардлагатай
5. Ус судлалын Улз-Дашбалбар, Улз-Баян-Уул харуулуудад резин завь шаардлагатай

УС, ЦАГ УУР СУДАЛГАА МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭНД

1. Бэлчээрийн төлөв байдлын ажиглалтад хэрэглэгдэх зургийн аппарат 15 ширхэг
2. Бэлчээрийн ургамлын ургац болон хөрсний чийгшил жинлэх цахилгаан жин 2 ширхэг
3. Хөдөө аж ахуйн цаг уурын Онон өртөөнд хөрсний чийг температурын ZL-6 автомат багаж

ТАЙЛАН БИЧСЭН:

ЦАГ УУР, ОРЧНЫ ТЕХНОЛОГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА:
МЭДЭЭЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА:

А.ШИНЭЧИМЭГ
Ж.МӨНХЧИМЭГ

УЦУОШТ-ИЙН ДАРГА

ХЯНАСАН:

Г.ГАРАМХИШИГ